



Төрийн бодлогын үр нөлөөг үр шим хүртэгч, цалинжигчаар тодорхойлох нь

MERIT төслийн зөвлөх, Мишэл Филион

Агуулга

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт
- Эрх тэгш байдал тогтоож байгаа эсэх
- Австралийн туршлага
- Өмнөд Африкийн туршлага
- Үр шим хүртэгчдийг хүйсээр ангилах
- Цалинжигчдыг хүйсээр ангилах
- Шидэт тоо-50%

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэгт төсвийн хөтөлбөр, бодлогууд эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөхийг системтэйгээр шалгахыг хэлнэ.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг нь зөвхөн тусгайлан эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөрүүдийг шинжлэх, “эмэгтэйчүүдэд зориулсан” тусдаа төсөв төлөвлөх бус, харин төрийн бүх хөтөлбөр, үйлчилгээ, бодлого дахь жендэрийн нөлөөллийг харгалзаж үзэх явдал юм.

Эрх тэгш байдал тогтоож байгаа эсэх

- Төсвийн үзүүлэлтүүд эрэгтэй, эмэгтэй хүмүүст ялгаатайгаар нөлөөлж болзошгүй учраас Засгийн газрын төсөв нь “жендэрийн хувьд саармаг” байж болохгүй.
- “Жендэрийн хувьд саармаг” гэдэг нь жендэрийн хувьд харалган, мэдрэмжгүй байна гэсэн үг.
- Энэ байдлаар эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг харгалзаагүйгээс зарим хөтөлбөр тэгш бус байдлыг гааруулах талтай.
- Төрийн аливаа хөтөлбөр, үйл ажиллагаа, арга хэмжээ нь ард иргэдийн дунд эрх тэгш бус байдлыг нэмэгдүүлж болзошгүй.

Австралийн туршлага

Засгийн газрын яамд, агентлагуудад тухайн жилийн төсөв ялангуяа улсын төсвийн зарлага охид эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх талаар шинжилгээ хийх шаардлага тавьдаг.

Өмнөд Африкийн туршлага

- Ядуу эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг тэргүүн ээлжинд авч үзэх зарчим, үнэт зүйлсийн цогц нь төсвийн зарлагыг хянах арга хэрэгсэл болдог.
- Энэ зорилгоор эрэмбэлэх, төлөвлөх, хянах эрх бүхий төрийн байгууллагуудыг чадавхжуулдаг.
- Эдгээр үйл ажиллагааны хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох иргэний нийгмийг чадавхжуулдаг.

Жендэрийн асуудлыг анхаарч үзэх

- Практикт төсөвлөлтийн үйл ажиллагаанд эдийн засгийн хувьд ач холбогдолтой байдлаар жендэрийг харгалзан үзэх нь амаргүй даваа юм.
- Энд зайлшгүй асуух ёстой асуулт бол төсөв боловсруулахдаа жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт шаардлагатай гэдгийг илтгэж буй юуг орхигдуулсан байж болзошгүй вэ?
- Жендэрийн дүн шинжилгээг дутмаг оруулах явдал багтана.
- Бидний санал: Яамд, ЗДТГ-ын зарцуулалт болон Сангийн яамны орлогын асуудал хэлэлцэгдэх бүрт нь жендэрийн дүн шинжилгээг шигтгэж оруулж өгөх нь зүйтэй.

Төсвийн микро хэмжээс

- Туршлагаас харахад төсвийн микро эдийн засгийн хэмжээс болох орлого, зарлагын бүрэлдэхүүн, эсвэл Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн бүтэц зэрэгт төвлөрөх нь хялбар байдаг.

Үр шим хүртэгчдийг хүйсээр ангилах

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хүрээнд төрийн зарлагын нөлөөллийг үнэлэхийн тулд үр шим хүртэгчдийг жендэрээр ангилахыг шаарддаг.
- “Үр шимийн нөлөөллийн” шинжилгээ хийх энэхүү аргачлал нь ард иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний үр шимийг баримжаалах нэг арга зам болгон тухайн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний зардлыг тооцоолдог байна.
- Энэ аргачлалд зарлагын мэдээллийг эдгээр үйлчилгээг ашигласан хүмүүсийн мэдээлэлтэй тулган хардаг. Ингэснээр тухайн хүйс, бүлэгт оногдож буй зардлын түвшинг тогтоох боломжтой болдог.

Цалинжигчдыг хүйсээр ангилал

Төр нь цалин хөлсөөр дамжуулан баялагийг хуваарилж, боломж олгож байдаг билээ.

Мөн түүнчлэн, төрийн үйлчилгээний зардал болон төрийн албан хаагчдын цалин хөлсний мэдээллийг хүйсийн мэдээлэлтэй тулгаж үзсэнээр аливаа зөрүүг харах боломжтой.

Merci.
